МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр Дугаар А/01 Номгон

"Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 2.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны Аймгийн хэмжээнд 2025 оныг "Эрүүл мэндийг дэмжих жил болгон зарлах тухай" 4/29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилгоор аймгийн "Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2.Нэрлэсэн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган манлайлан оролцохыг аймгийн Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Нэгдсэн эмнэлэг (Ж.Ганзул), идэвх санаачилга гарган холбогдох арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон хамтран ажиллахыг бүх шатны Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. "Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас (06 дугаар сарын 20), бүтэн (12 дугаар сарын 20) жилээр гаргаж аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын багт танилцуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т хариуцуулсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

6?5010030

[illegible]

625010027

Аймгийн Засаг даргын ..2025..оны ..01... дугаар сарын
..03...-ны өдрийн А/01 дугаар захирамжийн хавсралт

# "ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 17. Номгон

| № | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хариуцах албан тушаалтан | Хамтрах байгууллага | Хугацаа | Санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| **Нэг. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | | |
| Зорилго: Анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүдэд нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа өндөр нарийн мэргэжлийн оношилгоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | | | |
| 1.1 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2.26, Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Нэгдсэн эмнэлгийн цахим бүртгэлийн хэсгийн үйл ажиллагааг өргөжүүлж, бүртгэлийн ажилтныг нэмэгдүүлэх | Цахим бүртгэлийн ажилтны тоо | 2 | 5 | Ж.Ганзул С.Эрдэнэчулуун | Г.Лхагва-Очир Эмнэлгийн тусламжийн хэлтэс | III/15 | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.2 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Үзлэгийн цаг, орны хүлээгдлийг 3 хоног тутамд гаргаж, шаардлагатай тусламж үйлчилгээний чиглэлээр нэмэлт эмч нарыг томилж ажиллуулах | Орны хүлээгдлийн хоног<br>Нэмэлтээр ажилласан эмчийн тоо | 5-7 хоног<br>- | 1-3 хоног<br>3 | Ж.Ганзул С.Эрдэнэчулуун | Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтнүүд | III/03 | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.3 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Нэгдсэн эмнэлгийн амбулаторит уушги, дотоод шүүрэл, бөөр, зүрх судасны кабинетуудыг төрөлжүүлэн нэмэгдүүлж, үйлчлүүлэгчийн хүлээгдлийг бууруулах | Кабинетийн тоо | 1 | 4 | Ж.Ганзул С.Эрдэнэчулуун | Г.Лхагва-Очир Эмнэлгийн тусламжийн хэлтэс | V сар | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.4 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Амбулаторийн хөтчийн тоог нэмэгдүүлж, иргэдийг угтах үйлчилгээг стандартад нийцүүлэх | Хөтчийн тоо | 1 | 3 | Ж.Ганзул С.Эрдэнэчулуун | Г.Лхагва-Очир Эмнэлгийн тусламжийн хэлтэс | III/01 | Байгууллагын үйл ажиллагааны зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэхь заалт | Амбулаториор үйлчлүүлэгчдийн эмчийн үзлэгээс шинжилгээ бүрдүүлэх хүртэлх шат дамжлагыг бууруулах | Бууруулсан процессийн тоо | 4 | 3 | Ж.Ганзул С.Эрдэнэчулуун | Г.Лхагва-Очир Эмнэлгийн тусламжийн хэлтэс | III сар | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.6 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2.25 Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэхь заалт | Бөөр, цус, дотоод шүүрэл, уушги, андрологийн чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нараас цахимаар зөвлөгөө авч, Телемедицинийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, Цахим 5 дугаар эмнэлгийн туршлагыг нэвтрүүлэх | Өргөжүүлсэн тусламж үйлчилгээний тоо | 2 | 5 | Ж.Ганзул П.Ариунаа С.Эрдэнэчулуун | Цахим 5-р эмнэлэг | III сар | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.7 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэхь заалт | Хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн дуудлага хүлээн авах оператор эмчийг томилох. | Томилогдсон эмчийн тоо | 0 | 2 | Нэгдсэн эмнэлгийн ТУЗ Ж.Ганзул П.Ариунаа | А.Булганчимэг Эмнэлгийн тусламжийн хэлтэс | III/01 | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.8 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэхь заалт | Хүлээн авах яаралтай тусламжийн тасагт туслах сувилагч, эрэмбийн сувилагч ажиллуулах. | Эрэмбийн сувилагчийн тоо<br>Туслах Сувилагчийн тоо | 0<br>0.5 | 1<br>2 | ТУЗ Ж.Ганзул П.Ариунаа А.Даваадорж | Ш.Одбаяр Эмнэлгийн тусламжийн хэлтэс | III/01 | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.9 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА-ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэхь заалт | Дотор, мэдрэл, хүүхдийн тасагт туслах сувилагч ажиллуулах. | Туслах сувилагчийн тоо | 2 | 3 | НЭ-ийн ТУЗ П.Ариунаа Б.Наранбаатар А.Ганболд Т.Дуламсүрэн | Ш.Одбаяр Эмнэлгийн тусламжийн хэлтэс | III/01 | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.10 | Аймгийн 2024-2028 оны ЗДҮА- | Төрөх эмэгтэйчүүдийн тасагт хөтөч сувилагч ажиллуулан, дуут хөтөч нэвтрүүлэх. | Хөтчийн тоо | 0 | 2 | НЭ-ийн ТУЗ Ж.Ганзул | Б.Энхмандах Эмнэлгийн тусламжий | III/01 | Байгууллагын үйл |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | П.Ариунаа Ж.Солонго М.Болорчимэг | хэлтэс | | ажиллагаан ы зардал |
| 1.11 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/313 дугаар тушаал Эрүүл мэндийн яам, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны дэмжлэгт хяналтын зөвлөмжийн 26, 27 дугаар заалт | Нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн тасагт ар гэрийнхэнтэйгээ хамт төрөх зориулалтын өрөөг тохижуулах, мэдээлэл өгөх самбар ажиллуулах | Тохижуулсан өрөөний тоо | 0 | 2 | Ж.Ганзул П.Ариунаа М.Болорчимэг | Б.Энхмандах Эмнэлгийн тусламжийн хэлтэс | 06 сар | Байгууллаг ын үйл ажиллагаан ы зардал |
| 1.12 | | Нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн тасагт Жирэмсэн эхчүүдийг хянах өндөр хяналтат өрөөг зохион байгуулах | Өрөөний тоо | 0 | 1 | Ж.Ганзул П.Ариунаа М.Болорчимэг | Б.Энхмандах Эмнэлгийн тусламжийн хэлтэс | 03-11 сар | Байгууллаг ын үйл ажиллагаан ы зардал |
| 1.13 | | Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эх нярайг хүлээлгэж өгөх өрөөг үйлчлүүлэгчид ээлтэйгээр тохижуулах | Тохижуулсан өрөөний тоо | 0 | 1 | Ж.Ганзул П.Ариунаа М.Болорчимэг | Б.Энхмандах Эмнэлгийн тусламжийн хэлтэс | 06 сар | Байгууллаг ын үйл ажиллагаан ы зардал |
| 1.14 | | Гэр бүлийн уулзалт, зөвлөгөө, мэдээллийн өрөөг шинээр байгуулж тохижуулах | Тохижуулсан өрөөний тоо | 0 | 1 | П.Ариунаа Ц.Баясгалан М.Болорчимэг | Б.Энхмандах Эмнэлгийн тусламжийн хэлтэс | 03 сар | Байгууллаг ын үйл ажиллагаан ы зардал |
| 1.15 | | Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын кабинетаар үйлчлүүлэх эхчүүдэд зориулсан сэтгэлзүйн зөвлөгөө өгөх өрөөг шинээр нээж тохижуулах | Тохижуулсан өрөөний тоо | 0 | 1 | Ж.Ганзул М.Болорчимэг | Эмэгтэйчүүдийн зөвлөл | 03 сар | Төсөл хөтөлбөр Хандив тусламж |
| 1.16 | АЗД-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Мэс засал, хүүхэд, хавдар, арьс хөнгөвчлөх, дотор, эрчимт, мэдрэл, халдвартын тасгуудад ар гэрийнхэнд зориулсан уулзалтын өрөөг тохижуулах | Тохижуулсан өрөөний тоо | 1 | 7 | Ж.Ганзул П.Ариунаа Тухайн тасгийн эрхлэгч нар | Э.Даваасүрэн Эмнэлгийн тусламжийн хэлтэс | 07 сар | Байгууллаг ын үйл ажиллагаан ы зардал |
| 1.17 | MNS 7014:2023 стандарт эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага | Ажил мэргэжлийн онцлогтой уялдуулан хувцаслалт, энгэрийн тэмдэг, таних тэмдэг бүхий brandbook бүрдүүлэх. | Хэрэгжилтийн хувь | 20 | 100 | Ж.Ганзул П.Ариунаа Ц.Баясгалан Тасгийн эрхлэгч нар | О.Найгалмаа Эмнэлгийн тусламжийн хэлтэс | 06 сар | Байгууллаг ын үйл ажиллагаан ы зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.18 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт<br><br>Гэмтэл согогийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах төсөл | Гэмтлийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг сайжруулж, нутагшуулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байранд дадлагажуулах. | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо<br><br>Дадлагажуулах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо | 0<br><br>0 | 120<br><br>2 | Ж.Ганзул<br>П.Ариунаа | Э.Даваасүрэн<br>Эмнэлгийн тусламжийн хэлтэс<br>ГССҮТ | II-IV улирал д | Аймгийн орон нутгийн төсвөөс |
| 1.19 | | Гэмтлийн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг сум орон нутагт нь үзүүлэх | Ажилласан сумын тоо<br><br>Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 0<br><br>0 | 20<br><br>500 | Н.Энхжаргал<br>Ж.Ганзул | ГССҮТ,<br>Сумдын ЗДТГ, ЭМТ-ийн дарга нар | II-IV улирал д | ЭМГ<br>НЭ<br>Сумын ЭМТ-ийн зардал |
| 1.20 | | Бие даасан гэмтэл согог судлалын тасгийг шинээр байгуулах. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Ж.Ганзул<br>П.Ариунаа | Эмнэлгийн тусламжийн хэлтэс | II-III улирал д | |
| 1.21 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Аймгийн Засаг даргын хамтран баталсан Нэгдсэн эмнэлгийн амбулаторийг “Улсын жишиг” болгох ажлын төлөвлөгөө | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон гадаадад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж, ажлын байранд солилцон ажиллуулах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | 90 | ЭМГ<br>НЭ | ЭМЯ, ЭМХТ<br>АЗДТГ | Улирал бүр | ЭМЯ,<br>ЭМХТ-ийн санхүүжилт |
| 1.22 | | Нэгдсэн эмнэлгийн шинэ амбулаторийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 80 | 90 | ЭМЯ | ЭМГ<br>НЭ | III-IV улирал д | ЭМЯ<br>1.0 тэрбум |
| 1.23 | | Нэгдсэн эмнэлгийн шинэ амбулаторийг Олон улсын жишигт нийцүүлэн тохижуулах | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Аймгийн ЗДТГ | ЭМХТ<br>ЭМГ<br>НЭ | III-IV улирал д | Аймгийн ОНТ<br>500.0 сая |
| 1.24 | | Амбулаторийн гадна хаяг, орчны тохижилтыг стандартын дагуу зохион байгуулах | MNS7014:2023 стандартын явцын үнэлгээний хувь | 75 | 90 | Н.Энхжаргал<br>Ж.Ганзул | О.Найгалмаа<br>Э.Даваасүрэн<br>ЭТХэлтэс | I улирал д | НЭ-ийн үйл ажиллагааны зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.25 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 5, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Төрөх эмэгтэйчүүд, хүүхэд, мэдрэл, дотор, яаралтай тусламжийн чиглэлээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг ажлын байрны дадлагажуулах сургалтад хамруулах | Дадлагажуулах сургалтад хамрагдсан эмч нарын тоо | 8 | 10 | ЭМГ<br>НЭ | Сум, өрхийн ЭМТ-ийн дарга нар | Улирал бүр | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.26 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Сувилагч мэргэжилтнүүдийг солилцоогоор ажиллуулах | Солилцоогоор ажилласан сувилагчийн тоо | - | 10 | ЭМГ<br>НЭ | Сум, өрхийн ЭМТ-ийн дарга нар | Улирал бүр | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.27 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Оношийн зөрүү, хоног болоогүй нас баралтын тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж, чанарын өргөтгөсөн зохион байгуулах | Хурлын тоо<br><br>Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 0<br><br>- | 4<br><br>80 | Эмнэлгийн тусламжийн хэлтэс Г.Лхагва-Очир | НЭ, сум, өрхийн ЭМТ-ийн дарга нар | Улирал бүр | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.28 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Хавдрын эмчилгээний тариа найруулах ламинар боксыг шинэчлэх | Хими болон бай эмчилгээнд орсон хүний тоо | 17 | 25 | НЭ | Эмнэлгийн тусламжийн хэлтэс Г.Лхагва-Очир | IX сар | НЭ-ийн үйл ажиллагааны зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.29 | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 7 дахь заалт | Зүрх судасны өвчлөлийг бууруулах бүлэн уусгах, хэм судлалын оношилгоо эмчилгээг орон нутагтаа нэвтрүүлэх | Сургагдсан эмчийн тоо<br><br>Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 0<br><br>0 | 2<br><br>60 | Эмнэлгийн тусламжийн хэлтэс<br>Нэгдсэн эмнэлэг | Сонгдо эмнэлэг<br>ШУГТЭ<br>НЭ | III-IV улирал д | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.30 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Аймгаас гаралтай Хүний гавьяат эмч, анагаах ухааны доктор, төрөлжсөн мэргэшлийн эмч нартай хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | Төлөвлөгөө ний хэрэгжилтий н хувь | - | 90 | Н.Наранхатан<br>С.Эрдэнэчулуун<br>Эмнэлгийн тусламжийн хэлтэс, НЭ | НЭ<br>Сум, өрхийн ЭМТ-ийн дарга нар | III-IV улирал д | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 1.31 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Тэргүүлэх өвчлөл эндэгдлийг бууруулах чиглэлээр уламжлалт анагаах ухааны 5 заслын аргыг нэвтрүүлэх | Хэрэгжилтий н хувь | 0 | 80 | Н.Наранхатан<br>Эмнэлгийн тусламжийн хэлтэс | НЭ, СӨЭМТ, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага | II улирал д | Эрүүл мэндийн салбарын төсөв 3.0 сая |
| 1.32 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | “Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйг төлөвшүүлье” олон талт арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3 | ЭМГ<br><br>Ёс зүйн салбар хороо | НЭ, СӨЭМТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага | IV-XI сар | ЭМГ-3.0 сая<br>НЭ-5.0 сая<br>ХХЭМБ-500 мянга<br>СӨЭМТ-1.0 сая |
| 1.33 | | Эмнэлгийн ажилчдыг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах | Даатгалд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо | 0 | 240 | Аймгийн ЗДТГ-ын НЕХэлтэс | ЭМГ<br>НЭ | III сар | Аймгийн ОНТ 30.0 сая<br>Нэгдсэн эмнэлэг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.34 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.5 дахь заалт | Сувилагч мэргэжилтний ажил мэргэжлийн уралдаан, туршлага солилцох уулзалтыг говь, хангай бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах | Оролцсон эрүүл мэндийн байгууллагын тоо<br>Сувилагч нарын ур чадварын түвшин | 19<br>68.2 | 20<br>80 | ЭМГ | НЭ, Сум, өрхийн ЭМТ, бусад | II ба III улиралд | ЭМГ-1.0 сая. Сумын ЭМТ-500 мянга |
| 1.35 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт | "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тавих шаардлага" MNS7014:2023 стандартын дагуу орон нутгийн сургагч багшийг бэлтгэх | Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо | 2 | 40 | ЭМГ | НЭ, Сум, өрхийн ЭМТ, бусад | IV сар | НЭ-5.0 сая. СӨЭМТ-200 мянга |
| 1.36 | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/292 тушаал, Аймгийн Засаг даргын 2016 оны А/552 дугаар захирамж | Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах | Зохион байгуулсан сургалтын тоо<br>Хамрагдсан байгууллагын тоо | 1<br>25 | 2<br>25 | ЭМГ | ЭМЯ, НЭ,Сум, өрхийн ЭМТ, бусад | VI болон IX сард | ЭМГ-2.0 сая. СЭМТ-300 мянга |
| 1.37 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт | Эмнэлгийн тоног төхөөрөмж, ашиглалт, засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, туслах ажилтнуудыг чадавхижуулах сургалтад хамруулах | Хамрагдсан ажилтны тоо | - | 3 | ЭМГ, НЭ | Бүх шатны ЭМБ | I-III улиралд | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| **Хоёр. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ** | | | | | | | | | |
| Зорилго. Хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | | | | | |
| **1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх чиглэлээр** | | | | | | | | | |
| 2.1 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуулийг сурталчлан таниулах | Байршуулсан мэдээллийн тоо | - | Хандалтын тоогоор | ЭМГ | ААНБ, Төрийн байгууллага, НЭ, СӨЭМТ | Жилийн турш | Байгууллагын үйл ажиллагааны зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.1 дэх заалт Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль | | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | 2500 | | | | |
| 2.2 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт | “Маскаа зүүцгээе” аяныг зохион байгуулах | Аянд нэгдсэн албан байгууллагын тоо | 27 | 130 | ЭМГ, НЭ, СӨЭМТ | Төрийн байгууллага, ААНБ | X-XII-III сар | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| | | | Маск зүүж хэвшсэн иргэдийн хувь | 2 | 20 | | | | |
| 2.3 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 2.3.1.3, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай А/27, А/25 дугаар хамтарсан тушаал | “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээн зохион байгуулах | Уралдаанд оролцсон сургуулийн тоо | 10 | 31 | БГ, ЭМГ, Сургагч багш нар | СЗДТГ, ЕБС-ууд СӨЭМТ, НЭ, Шүдний эмнэлгүүд | IX-X сар | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал- 2.5 сая, ЭМГ-1.0 сая, БГ-1.0 сая, ӨЭМТ-өөс тус бүр 250 мянга |
| | | | Оролцсон 4, 5, 6 дугаар ангийн сурагчдын тоо | 200 | 2000 | | | | |
| 2.4 | | Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэсэн хүүхдийн шүдний өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх төсөлт арга хэмжээ зохион байгуулах | Эрүүлжүүлсэн хүүхдийн хувь | 20 | 40 | БГ, СӨЭМТ | НЭ, Хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд | Жилийн турш | ЭМДС, Эрүүл мэндийн байгууллагын төсөв |
| 2.5 | “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зорилт 2.2, ЭМС-ын 2024 оны “ХПВ- | Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины ач холбогдлыг иргэдэд сурталчлан, вакцинд хамралтыг нэмэгдүүлэх | Хамралтын хувь | 43 | 60 | Боловсролын газар | СЗДТГ, ЭМГ, СӨЭМТ, Төрийн байгууллага, ААНБ | II-III улирал | ЭМДС, Эрүүл мэндийн байгууллагын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/455 дугээр тушаал | | | | | | | | |
| 2.6 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамжаар батлагдсан "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" 2023-2026 арга хэмжээний төлөвлөгөө | "Өсвөр үеийн эрүүл мэнд" зорилтот арга хэмжээ зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулсан нэгжийн тоо | 10 | 25 | ЭМГ, Өсвөр үеийн кабинет, СӨЭМТ | Сумдын ЗДТГ, ЕБС-ууд, Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулиуд | III-XI сар | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал-3.0 сая НЭ, СӨЭМТ-ийн үйл ажиллагааны зардал |
| | | | Хамрагдсан хүүхдийн тоо | 1300 | 4500 | | | | |
| 2.7 | | "Хүүхдийн зуны сувилал" ажиллуулах | Ажиллуулсан нэгжийн тоо | 9 | 20 | СӨЭМТ | Сумдын ЗДТГ | VI-VII сар | СЗДТГ, СӨЭМТ |
| | | | Жингийн алдагдалтай 6-59 сартай хамрагдсан хүүхдийн тоо | 90 | 200 | | | | |
| 2.8 | | Нэгдсэн эмнэлгийг түшиглэсэн хүүхдийн сувилал ажиллуулах | Хамрагдсан хүүхдийн тоо | 0 | 50 | НЭ, ӨЭМТ | ЭМГ | III-IV улирал | Баянхонгор СЗДТГ 5.0 сая |
| 2.9 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.2 дахь заалт | "Эрүүл хүүхэд-5" дадал эзэмшүүлэх төсөлт арга хэмжээ зохион байгуулах (I.Ус уух, II.Гараа зөв угаах, III.Шүдээ тогтмол угаах, IV.Дасгал хөдөлгөөн хийх, V.Чихэрлэг хүнснээс татгалзах) | Сургалтад хамрагдсан эцэг эхийн тоо | - | 2000 | ЭМГ, БГ | СЗДТГ, СӨБ, Сум, өрхийн ЭМТ | III-XI сар | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 3.5 сая, Салбарын үйл ажиллагааны зардал |
| | | | Дадал эзэмшсэн хүүхдийн хувь | - | 50 | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | - | 300 | | | | |
| 2.10 | | “Уламжлалт анагаах ухаан ба эрүүл амьдрал” явуулын өдөрлөг зохион байгуулах | Хамрагдсан байгууллагын тоо | - | 10 | ЭМГ, Дэрсил эмнэлэг | НЭ, УАУ-ны эмч нарын баг, Төрийн байгууллагууд | II сар тутамд | Салбарын үйл ажиллагааны зардал |
| 2.11 | “Алсын хараа 2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилт 2.2, Аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамаар батлагдсан “Эрүүл иргэн-Хонгорын баялаг” 2023-2026 арга хэмжээний төлөвлөгөө | “Өөрийгөө урлая” эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх аян зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулсан нэгжийн тоо | 20 | 24 | ЭМГ, СӨЭМТ | СӨЭМТ, Төрийн байгууллага, ААНБ | III-X сар | Сум, өрхийн ЭМТ-ийн үйл ажиллагааны зардал |
| | | | Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 3500 | 7000 | | | | |
| | | | Жингээ бууруулсан иргэдийн эзлэх хувь | - | 5 | | | | |
| 2.12 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамаар батлагдсан “Эрүүл иргэн-Хонгорын | “Эрүүл мэндийнхээ төлөө-Өөртөө цаг гаргая” нийтийн цэнгээнт бүжгийн сургалт зохион байгуулах. | Оролцогч байгууллагын тоо | 34 | 44 | БТСГ | Төрийн байгууллагууд, Шинэ Ертөнц, Хонгор бүжгийн клуб | III-VII сар | БТСГ-ын үйл ажиллагааны зардал |
| | | | Хамт олноороо хийж хэвшүүлсэн | 14760 | 17000 | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | баялаг" 2023-2026 арга хэмжээний төлөвлөгөө | | хүний тоо | | | | | | |
| 2.13 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2023 онд хэрэгжүүлэх Эрүүл мэндийн зорилтын 9. | "Алтан 1000 хоног" төсөлт арга хэмжээ хэрэгжүүлэх | Хамрагдсан залуу гэр бүлийн тоо | - | 350 | Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс | Иргэний нийгмийн байгууллага, Өрхийн эрүүл мэндийн төвүүд | Жили йн турш | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал-5.0 сая. |
| 2.14 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.5 дахь заалт | "Боломжийг бүгдэд" тусгай хэрэгцээт хүүхдийг спортоор хөгжүүлэх төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх | Хамрагдсан багш, арга зүйч нарын тоо | 0 | 40 | БТСГ | АЗДТГ | III-XI сар | Байгууллаг ын төсөв |
| | | | Хамрагдсан хүүхдийн тоо | 90 | 130 | | | | |
| 2.15 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1 дэхь заалт | "Эрүүл иргэн–Хонгорын баялаг 2025" ажлын байрны дасгал хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлэх | Ажлын байрны дасгалыг хийж хэвшүүлсэн байгууллагын тоо | 520 | 19.000 | БТСГ, Сумдын Биеийн тамирын арга зүйч нар | Сумдын ЗДТГазар, Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд | III - VI | БТСГазар |
| 2.16 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2023 онд хэрэгжүүлэх Эрүүл мэндийн | "Ахмадын биеийн тамирыг дэмжих аян" зохион байгуулах | Хамрагдсан ахмадын тоо | 300 | 500 | БТСГазар Ахмадын хороо | Сумдын ЗДТГазар | X | БТСГазар |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зорилтын 1. МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 2.1.4.4 дэх заалт | | | | | | | | |
| 2.17 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.7 дахь заалт | Архины хамааралтай иргэдийг эрт илрүүлэх, нөхөн сэргээх, 24-36 сар хянах арга хэмжээг хэвшүүлэх | Хамтарсан байгууллагын тоо | 24 | 44 | Жаргалтай амьдрал төв | СЗДТГ, СӨЭМТ | Хагас бүтэн жилд | Жаргалтай амьдрал төвийн үйл ажиллагаан ы зардал |
| | | | Хяналтад хамрагдалтын хувь | 35 | 50 | | | | |
| 2.18 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 5, МУ-ын Ерөнхий сайдын 71 дүгээр захирамжаар батлагдсан 2024-2027 онд хэрэгжүүлэх "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл | "Эрүүл чийрэг эр хүн" аян зохион байгуулах | Аян зохион байгуулсан нэгжийн тоо | 22 | 27 | СӨЭМТ | Сумын ЗДТГ, СӨЭМТ, НЭ, | III-X сар | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 8.0 сая, Баянхонгор сумын ЗДТГ 1.0 сая |
| | | | Аянд хамрагдсан хүний тоо | 2883 | 3600 | | | | |
| 2.19 | | "Эрүүл мэндийн даатгал ирээдүйн баталгаа"- арга хэмжээ хэрэгжүүлэх | Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хамралтын хувь | 63,5 | 70 | ЭМДХэлтэс Сумдын ЗДТГ | Багийн дарга нар Оюутны холбоо | Жилийн турш | Үйл ажиллагаан ы зардал |
| | | | Малчдын хамралтын хувь | 30 | 60 | | | | |
| | | | Оюутан залуусын хамралтын хувь | 90 | 95 | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.4 дэх заалт | | | | | | | | |
| 2.20 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.8 дахь заалт | “Эмийн зохистой хэрэглээ эрсдэлээс сэргийлнэ” арга хэмжээг хэрэгжүүлэх | Хамрагдсан иргэдийн тоо | - | 2000 | ЭМГ | Баянхонгор сумын ЗДТГ, Эм холбоо | III-VI сар | Баянхонгор сумын ЗДТГ 400.0 мянга |
| | **2. Хүн амын эрүүл мэндийг дэмжих нийгмийн эрүүл мэндийн орчин бүрдүүлэх чиглэлээр** | | | | | | | | |
| 2.21 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.3.2 дахь заалт | Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, боловсруулах, устгах тогтолцоог сайжруулах | Шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 0 | 85 | ЭМГ | АЗДТГ<br>ЗӨСТ<br>Сум, өрхийн ЭМТ,<br>Хувийн хэвшлийн ЭМБ<br>ААНБ | Жилийн турш | Салбарын үйл ажиллагаан ы зардал |
| 2.22 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 3.4.3.4, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.3.6 дахь заалт | Эко нойлын тоог нэмэгдүүлэх | Эко нойлоор хангагдсан өрхийн тоо | 70 | 105 | ЭМГ<br>Баянхонгор сумын ЗДТГ | Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс | VI-X сар | Баянхонгор сумын ЗДТГ-аас 140.0 сая |
| 2.23 | | Уурын зуухны яндanд усан шүүлтүүр тавих | Тавьсан шүүлтүүрийн тоо | 2 | 13 | Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, ААНБ | Баянхонгор сумын ЗДТГ | Жилийн турш | ААНБ-ын төсөв |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.24 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7.11, 2.2.3.1 дэх заалт | Ухаалаг усан сангийн тоог нэмэгдүүлэх | Нэмэгдүүлсэн тоо | 38 | 44 | Баянхонгор СЗДТГ | "ЧандманьБаян хонгор" ХК | Жилийн турш | Баянхонгор СЗДТГ |
| 2.25 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 дахь заалт | Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах аян зохион байгуулах | Аян зохион байгуулсан нэгжийн тоо | - | 21 | Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс | Сумдын ЗДТГ | III-X сар | Үйл ажиллагааны зардал |
| | | | Хэрэглээ буурсан хувь | - | 50 | | | | |
| 2.26 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 3.4.3.7, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.3.6 дахь заалт | Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд иргэд, үйлчлүүлэгчдэд таатай орчин бүрдүүлж, эдэлбэр газрын ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, түр салхилах сүүдрэвч, сандал, гэрэлтүүлэг, хогийн сав зэрэг гадна тохижилтын ажлыг хийх | Ногоон байгууламж ийн эзлэх хувь | - | 80-аас доошгүй хувь | Байгаль орчны газар<br>Эрүүл мэндийн газар | Бүх шатны Төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагууд | Жилийн турш | Байгууллагын үйл ажиллагааны зардал |
| 2.27 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 2.3.1.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамжаар батлагдсан "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" 2023- | "Аюулгүй дотно харилцаа" бэлгийн замын халдвараас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах | Сургалт хийсэн нэгжийн тоо | - | 24 | НЭ, СӨЭМТ | Сумдын ЗДТГ | Жилийн турш | Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардал,<br><br>Баянхонгор СЗДТГ 10.0 сая |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | | Сургалтад хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийг тоо | - | 3000 | Залуус ТББ Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, ААНБ | ЭМГ, НЭ, Баянхонгор СЗДТГ Сумдын ЗДТГ, ЭМГ | Жилийн турш | ААНБ-ын зардал |
| | | | Шинжилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн тоо | - | 2000 | | | | |
| | | | ЭБЭ, ЭБҮ-ийн судалгаа хийх | - | Судалгаа | | | | |
| | | | Бэлгэвч байршуулж хэвшсэн зочид буудлын хувь | - | 90 | | | | |
| 2.28 | | "Эрүүл мэндийн салбарын эмчилгээний хоолны тогооч нарыг чадавхжуулах" сургалт зохион байгуулах | Оролцогчдын тоо | - | 25 | ЭМГ | НЭ ӨЭМТ | III сар | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 3.0 сая, Сумдын ЭМТ |
| 2.29 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 2.1.4.1 дэх заалт | Иргэдийн дасгал хөдөлгөөн, нийтийн биеийн тамираар хичээллэх зориулалтын зам талбай бүхий орчин бүрдүүлэх | Орчин бүрдүүлсэн хувь | 50 | 80 | ЭМГ БТСГ Сумдын ЗДТГ | Төрийн болон төрийн бус байгууллагууд | Жилдээ | Байгууллага, орон нутгийн төсвөөс |
| | | | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | | | | | | |
| **Гурав. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | | |
| Зорилго: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургалтад хамруулан, төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөн зохион байгуулах | | | | | | | | | |
| 3.1 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны | Хүний нөөцийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | - | 100 | | | I улирал | Салбарын үйл ажиллагааны зардал |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 4, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | | Биелэлтийн хувь | | | Эрүүл мэндийн газар | Бүх шатны Эрүүл мэндийн байгууллага | | |
| 3.2 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Эрүүл мэндийн салбарын удирдлагуудыг гадаад сургалтад хамруулах /удирдлага, эмнэлгийн тусламж үйлчилгээ, дэмжих үйл ажиллагаа/ | Сургалтад хамрагдсан удирдлагын тоо | 1 | 15 | ЭМГ, НЭ хүний нөөц | ЭМХТ, ЭМЯ | I улирал | ЭМЯ 440.0 сая (120,0 доллар) |
| 3.3 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн 2.3.4.1, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.1.5 | Улсын жишиг амбулатори болгох ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлгийн эмч ажилчдыг гадаадад туршлага судлуулах | Сайн туршлага нэвтрүүлсэн тоо<br><br>Хамрагдсан мэргэжилтний тоо | -<br><br>- | 15<br><br>40 | ЭМГ-ын Хүний нөөц, НЭ-ийн дарга, Хүний нөөцийн мэргэжилтэн | ЭМЯ, ЭМХТ | I улирал | ЭМЯ |
| 3.4 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Үндсэн болон мэргэшил дээшлүүлэх, төрөлжсөн мэргэшлээр суралцуулах | Хэрэгжилтийн хувь | 12 | 91 | Эмнэлгийн тусламжийн хэлтэс, ЭМГ, НЭ хүний нөөц | ЭМЯ, ЭМХТ АЗДТГ | Улирал бүр | Төрийн сан ЭМХТ |
| 3.5 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.1.4 | Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай мэргэжлээр эмч мэргэжилтнийг мэргэшил дээшлүүлж, сургаж бэлтгэх | Мэргэшсэн хүний тоо | - | 9 | ЭМГ, НЭ-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн | ЭМХТ | I-II улирал | ЭМХТ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Нэгдсэн эмнэлэгт эрчимт сэхээн амьдруулах, төрөх эмэгтэйчүүд, хүүхэд, лаборатори, дүрс оношилгоо, нярай, яаралтай тусламжийн чиглэлээр үндэсний баг ажиллуулах | Хэрэгжилтийн хувь | - | 100 | ЭМГ, НЭ Хүний нөөц, Сургалт эрдэм шинжилгээ инновацийн алба | Зөвлөх баг, дэмжих баг | I-XI сар | ЭМЯ, ЭМХТ, НЭ |
| 3.7 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.5 дахь заалт | "Удирдлагын хөгжил, манлайлал" сэдэвт чадавхжуулах сургалтад хамруулах | Хамрагдсан удирдлагууды н тоо | 0 | 24 | Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн мэргэжилтэн | Сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо Удирдлагын академи | III сар | Салбарын үйл ажиллагаан ы зардал |
| 3.8 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, дэхь заалт | Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах | Эмч мэргэжилтний тоо | - | 60 | Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэг | Сумын эрүүл мэндийн төвүүд | III-IV сар | ЭМГ, НЭ тус бүр 1,0 сая, СӨЭМТ-үүд тус бүр 100 мянган төг |
| 3.9 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, дэхь заалт | Лавлагаа шатлалын эмнэлгүүдэд нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, инженер техник, үйлчилгээний ажилчдыг ажлын байрны дадлагажуулах болон чадавхжуулах сургалтад хамруулах | Хэрэгжилтийн хувь | - | 100 | ЭМГ, НЭ Хүний нөөц, Сургалт эрдэм шинжилгээ инновацийн алба | ЭМХТ, лавлагаа шатлалын эмнэлгүүд | III-XII сар | Улсын төсөв |
| 3.9 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 7, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл | Зүрх судас, осол гэмтлийн шалтгаант нас баралтын бууруулах чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | - | 100 | ЭМГ, НЭ | Үндэсний зөвлөн туслах баг | III-XII сар | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, ЭМГ, НЭ, СЭМТ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | | | | | | | | |
| 3.10 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эрүүл мэндийн зорилтын 4, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Нэгдсэн эмнэлгийн тасаг нэгжүүдэд, сумдын эмч сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг ажлын байрны дадлагажуулах сургалтад хамруулах | Удирдамж хөтөлбөрийн тоо<br><br>Хэрэгжилтийн хувь | 2<br><br>100 | 5<br><br>100 | Эмнэлгийн тусламжийн хэлтэс, Сургалт эрдэм шинжилгээ инновацийн алба | Сумын эрүүл мэндийн төвүүд | III-XI сар | Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаан ы зардал |
| 3.11 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалт | Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн албан хаагчдыг Удирдлагын манлайлал, бодлогын баримт бичиг, боловсруулах сургалтад хамруулах | Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн-15 Нэгдсэн эмнэлгийн албадын дарга-15 | - | 30 албан хаагч | Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн мэргэжилтэн | Удирдлагын академи, Нэгдсэн эмнэлэг | IV сар | ЭМГ-2.0 сая. Нэгдсэн эмнэлэг-3.0 сая |
| 3.12 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4, 2.2.1.5 дахь заалт | Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ёс зүйн 2 удаагийн сургалтад хамруулах | Хамрагдсан хүний тоо | - | 80 | Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг | Сум, өрхийн ЭМТ-үүд | III сар | ЭМГ, НЭ, Сум, өрхийн ЭМТ-үүд |
| 3.13 | МУ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх ЗГҮАХ-ийн | Харьяа нутаг дэвсгэрийн Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа нийгмийн эрүүл мэндийн ажилтныг | Нийгмийн баталгаагаар | - | 24 | Эрүүл мэндийн газар, | Сум, өрхийн Эрүүл | Жилийн турш | Байгууллаг ын төсөв |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.3.4.2, 2.3.4.3, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт | тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломж, нийгмийн баталгаагаар хангах | хангагдсан НЭМА-ны тоо | | | Сумдын Засаг даргын тамгын газар | мэндийн төвүүд | | |

--------------------oOo --------------------